

## **БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ТӨВӨГШЛИЙН АНГИЛАЛЫГ ЗОРИУЛАЛТ, ХҮЧИН ЧАДЛААР НЬ ТОГТООХ ДҮРЭМ**

### **Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Барилгын тухай хуулийн 10.1-д заасан барилга байгууламжийн төвөгшлийн ангилалыг түүний зориулалт, төрөл, хүчин чадалтай уялдуулан тогтооход энэхүү дүрмийг мөрдөнө.

1.2. Барилга байгууламжийн зориулалт, төрөл, хүчин чадлыг Барилгын тухай хууль болон барилга байгууламжийн норматив баримт бичигт зааснаар тусгаж хэрэгжүүлнэ.

### **Хоёр. Барилга байгууламжийн төвөгшлийн ангилалыг хэрэглэх хүрээ**

2.1. Барилга байгууламжийн төвөгшлийн ангилал нь барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл олгох, барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх, барилгын ажлын зөвшөөрөл олгох, барилга байгууламжийг эхлүүлэх, үргэжлүүлэх, ашиглалтад оруулах, барилгын салбарын мэргэжилтэнд мэргэшлийн зэрэг олгох, сунгах, зөвлөх үйлчилгээ үзүүлэх, барилгын ажилд захиалагчийн хяналт тавих зэрэг үйл ажиллагааг зохицуулах үндэслэл болно.

### **Гурав. Барилга байгууламжийн төвөгшлийн ангилал**

3.1. Барилга байгууламжийн төвөгшлийн ангилалыг тогтооходоо доорх үзүүлэлтүүдийг харгалзан үзнэ. Үүнд:

- барилга байгууламжийн зориулалт, хүчин чадал, овор хэмжээ;
- барилга байгууламжийн өндөр, урт, эзлэхүүн, талбай;
- барилгажилтын нягтрал;
- барилга байгууламжийн эрсдэлийн түвшин;
- галын аюулгүй байдлын зэрэглэл;
- эдийн засаг, нийгэм, экологийн үр дагаварт нөлөөлж болзошгүй техникийн шинж чанар.

3.2. Барилга байгууламжийн инженер хайгуулын судалгаа болон барилгын дотор инженерийн шугам сүлжээ, гадна талбайн тохижилтын ангилалыг энэ дүрмийн 3.1-д заасан ангилалтай уялдуулан тодорхойлно.

3.3. Төвөгшлийн ангилалд хамруулах барилга байгууламжийн төрлийг энэ дүрмийн хавсралтаар тогтоосон болно.

## **Дөрөв. Барилга байгууламжийн ашиглалтын явцад төвөгшлийн ангилалд өөрчлөлт оруулах**

4.1.Барилга байгууламжийн ашиглалтын хэвийн нөхцөлийг хангах зорилгоор барилга байгууламжийн зориулалт, хүчин чадал, овор хэмжээ зэрэг техникийн шинж чанарыг бүхэлд нь буюу хэсэгчлэн өөрчилж засварласан, өргөтгөл шинэчлэлт хийсэн бол тухайн барилга байгууламжийн төвөгшлийн ангилалд өөрчлөлт оруулах үндэслэл болно.

4.2.Барилга байгууламжийн зориулалт, хүчин чадал, овор хэмжээ, төлөвлөлт, техникийн шинж чанар нь өөрчлөгдөөгүй үндсэн бүтээц болон инженерийн шугам сүлжээг өөрчлөн засварлаж шинэчлэлт хийгдсэн барилга байгууламжийн төвөгшлийн ангилал хэвээр байна.

4.3. Өмчлөгч, эзэмшигч нь барилга байгууламжид эвдрэл, гэмтэл учруулсан, зохих мэргэжлийн байгууллагын зөвшөөрөлгүйгээр үндсэн хийц, бүтээц, төлөвлөлт, зориулалтыг өөрчилсөн, тухайн барилга байгууламжид байгаль орчин, хүний амь нас, эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлсэн ашиглалтын хэвийн нөхцөлийг алдагдуулж болзошгүй үйл ажиллагаа эрхлэн барилга байгууламжийн төвөгшлийн ангилалд хамаарах зориулалт, төрөл, хүчин чадал, техникийн шинж чанарыг өөрчилж болохгүй.

Барилга байгууламжийн төвөгшлийн ангилалыг зориулалт,  
хүчин чадлаар нь тогтоох дүрмийн хавсралт

**Барилга байгууламжийн төвөгшлийн ангилал тус бүрд хамаарах барилга байгууламжууд**

№	Ангилал төрөл	1. Барилгын ажлын зөвшөөрөл шаардахгүй барилга байгууламж	2. Бага төвөгшилтэй барилга байгууламж	3. Дунд зэргийн төвөгшилтэй барилга байгууламж	4. Өндөр төвөгшилтэй барилга байгууламж	5. Онцгой төвөгшилтэй барилга байгууламж
		0	1	2	3	4
1	Орон сууц	1.1. 7 метр хүртэл өндөртэй 200м <sup>2</sup> хүртэл талбайтай нэг айлын орон сууц	2.1. 15 метр хүртэл өндөр нэг айлын орон сууц, олон айлын болон блокчилсон орон сууц	3.1. 15-31 метр хүртэл өндөртэй олон давхар орон сууцны барилга	4.1. 31-51 метр хүртэл өндөртэй олон давхар орон сууцны барилга	5.1. 51 метрээс дээш өндөртэй (16 давхраас дээш) орон сууцны өндөр барилгууд
2	Төрөл бүрийн зориулалттай олон нийтийн барилга		2.2. 15 метр хүртэл өндөртэй орон сууцнаас бусад төрөл бүрийн зориулалттай олон нийтийн барилга байгууламжууд	3.2. 15-31 метр хүртэл өндөртэй орон сууцнаас бусад зориулалттай олон давхар барилга байгууламж  3.3. Өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асрамжийн байрны барилга	4.2. 31-51 метр хүртэл өндөртэй орон сууцнаас бусад зориулалттай олон давхар барилга байгууламж  4.3. Хүн олноор нэгэн зэрэг цуглах барилга (Энэ хавсралтын 2.7; 3.13 -д зааснаас бусад)  4.4. Түүх соёлын дурсгалт барилга байгууламжийн сэргээн засварлах  4.5. Музей, үзэсгэлэнгийн барилга байгууламж  4.6. Сүм, хийдийн барилга байгууламж  4.7. Архивын барилга байгууламж	5.2. 51 метрээс дээш өндөртэй (16 давхраас дээш) орон сууцнаас бусад зориулалттай олон давхар барилга байгууламж  5.3. Тусгай нөхцөл, техникийн даалгавар шаардагдах онцгой зориулалттай барилга байгууламж (засгийн газрын ордон, телевиз, эрчим хүчний станц, батлан хамгаалах болон хилийн цэргийн зориулалттай барилга байгууламжууд гэх мэт)
		-	2.3. 36 метрээс бага алгаслалтай барилга байгууламж	3.4. 37-60 метр хүртэл алгаслалтай барилга байгууламж	4.8. 61 метрээс дээш алгаслалтай барилга байгууламж	-

0	1	2	3	4	5	6
3	Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын барилга	-	-	3.5. 100 хүртэл хүүхдийн сургуулийн өмнөх боловсролын байгууллагын барилга	4.9. 101-ээс дээш хүүхдийн сургуулийн өмнөх боловсролын байгууллагын барилга	-
4	Сургууль, дотуур байр			<p>3.6. 1000 хүртэлх сурагчтай сургуулийн хичээлийн байрны барилга</p> <p>3.7. Тусгай сургалтын /үйлдвэр сургалтын төв/ байртай хичээлийн байрны барилга</p> <p>3.8. Их дээд сургуулийн хичээлийн байрны барилга</p> <p>3.9. 300 хүртэлх хүүхдийн дотуур байрны барилга</p> <p>3.10. Хүүхдийн сургалтын спорт заал</p>	<p>4.10. 1001-ээс дээш сурагчтай сургуулийн хичээлийн байрны барилга</p> <p>4.11. 301-ээс дээш хүүхдийн дотуур байрны барилга</p>	-

0	1	2	3	4	5	6
5	Эмнэлгийн барилга байгууламж		<p><b>2.4.</b> Өрхийн эрүүл мэндийн төв, уламжлалт бариа заслын эмнэлэг 10.000 хүн амд үйлчлэх хүрээтэй</p> <p><b>2.5.</b> 15 хүртэл ортой эрүүл мэндийн төвийн барилга</p> <p><b>2.6.</b> Эмийн сангийн барилга</p>	<p><b>3.11.</b> 100 хүртэл ортой нэгдсэн эмнэлгийн барилга</p> <p><b>3.12.</b> Тусгай зориулалтын 60 хүртэл ортой эмнэлгийн барилга байгууламж /халдварт, гэмтэл, хүүхдийн, өндөр настны, төрөх гэх мэт/</p>	<p><b>4.12.</b> 101-ээс дээш ортой нэгдсэн эмнэлгийн барилга</p> <p><b>4.13.</b> Тусгай зориулалтын 61-ээс дээш ортой эмнэлгийн барилга байгууламж /халдварт, гэмтэл, хүүхдийн, өндөр настны, төрөх гэх мэт/</p>	
6	Худалдаа, үйлчилгээний барилга байгууламж		<p><b>2.7.</b> 1000м<sup>2</sup> хүртэл талбайтай худалдаа, үйлчилгээний барилга байгууламж</p>	<p><b>3.13.</b> 1001-5000м<sup>2</sup> хүртэл талбайтай худалдаа, үйлчилгээний барилга байгууламж</p>	<p><b>4.14.</b> 5001 м<sup>2</sup>-аас дээш талбайтай худалдаа, үйлчилгээний барилга байгууламж</p>	-

0	1	2	3	4	5	6
7	Үйлдвэрийн барилга байгууламж	-	<p><b>2.8.</b> 1000м<sup>2</sup> хүртэл талбайтай үйлдвэрийн барилга байгууламж</p>	<p><b>3.14.</b> 1001-5000м<sup>2</sup> хүртэл талбайтай үйлдвэрийн барилга байгууламж</p> <p><b>3.15.</b> Бичил, ил уурхайн үйлдвэрийн барилга байгууламж</p>	<p><b>4.15.</b> 5001-10000м<sup>2</sup> хүртэл талбайтай үйлдвэрийн барилга байгууламж</p> <p><b>4.16.</b> Өндөр температурт боловсруулалт хийдэг бодис, химийн бодис, тос усны байнгын үйлчлэлд ажиллах бетон хийц эдлэлийн үйлдвэр.</p>	<p><b>5.4.</b> 10001м<sup>2</sup> –аас дээш талбайтай үйлдвэрийн барилга байгууламж</p> <p><b>5.5.</b> Энэ хавсралтад заагдсанаас бусад Барилгын тухай хуулийн 32.1.5-д тусгагдсан үйлдвэрийн барилга байгууламж</p> <p><b>5.6.</b> Уул уурхайн ашиглах болон боловсруулах үйлдвэрийн барилга байгууламж, гүний уурхайн технологийн барилга байгууламж</p> <p><b>5.7.</b> Барилгын динамик ачаалалд (чичиргээ, доргио) ажиллах тоног төхөөрөмжийн төмөр бетон суурь, металл болон төмөр бетон тулгуур, баганы хийц үйлдвэрлэх үйлдвэрийн барилга байгууламж</p>

0	1	2	3	4	5	6
8	Агуулах		2.9. 4000м <sup>2</sup> хүртэл талбайтай агуулахын барилга байгууламж	3.16. 4001-25000м <sup>2</sup> хүртэл талбайтай агуулахын барилга байгууламж	4.17. 25001-40000 м <sup>2</sup> хүртэл талбайтай агуулахын барилга байгууламж  4.18. Нунтаг болон үрэл хэлбэрийн материалыг их хэмжээгээр хадгалах тусгай агуулах	5.8. 40001 м <sup>2</sup> -аас дээш талбайтай агуулахын барилга байгууламж  5.9. Тэсэрч дэлбэрэх, тэсэлгээний бодис, химийн хорт болон аюултай бодис хэрэглэх, хадгалах, барилга байгууламж
9	Авто машины зогсоолын барилга байгууламж	-	2.10. Зоорьгүй, нэг давхар, машин тус бүр тусдаа бокстой 30 хүртэл автомашины барилга байгууламж	3.17. 31-100 хүртэл автомашины барилга байгууламж  3.18. 100 хүртэл автомашины автомат зогсоолын байгууламж, суурь	4.19. 101-800 хүртэл автомашины барилга байгууламж  4.20. 101-ээс дээш автомашины автомат зогсоолын байгууламж, суурь	5.10. 801-ээс дээш автомашины барилга байгууламж
10	Эрчим хүчний эх үүсвэр	-	2.11. 0.1 МВт хүртэл хүчин чадалтай эрчим хүчний эх үүсвэр	3.19. 0.1 - 5МВт хүртэл хүчин чадалтай эрчим хүчний эх үүсвэр	4.21. 5 - 100 МВт хүртэл хүчин чадалтай эрчим хүчний эх үүсвэр	5.11. 100 МВт-аас дээш хүчин чадалтай эрчим хүчний эх үүсвэр

0	1	2	3	4	5	6
11	Дулааны эх үүсвэр	1.2. Тусгай зөвшөөрөл шаардлагагүй барилгын өөрийн бие даасан эх үүсвэр	2.12. 115°C хүртэл температуртай ус халаах, 0.07 МПа хүртэл даралттай уур үйлдвэрлэх зуух	3.20. 50 МВт хүртэл хүчин чадалтай 200°C хүртэл температуртай ус халаах, 3.9 МПа хүртэл даралттай уур үйлдвэрлэх зуух	4.22. 51 МВт-с дээш хүчин чадалтай 200°C хүртэл температуртай ус халаах, 3.9 МПа хүртэл даралттай уур үйлдвэрлэх зуух	5.12. 200°C-с их температуртай ус халаах, 3.9 МПа-с их даралттай уур үйлдвэрлэх зуух. дулааны цахилгаан станц
12	Дулаан хуваарилах төв		2.13. 15 МВт хүртэл хүчин чадалтай 115°C хүртэл температуртай ус усны, 0.07 МПа хүртэл даралттай уур усны дулаан солилцуулагчтай дулаан хуваарилах төв	3.21. 15 МВт хүртэл хүчин чадалтай 200°C хүртэл температуртай ус усны, 3.9 МПа хүртэл даралттай уур усны дулаан солилцуулагчтай Хэрэглэгч дулаан хуваарилах төв хоёрын байршлын өндрийн зөрүү нь 51 метрээс ихгүй дулаан хуваарилах төв	4.23. 15 МВт ба түүнээс дээш хүчин чадалтай 200°C хүртэл температуртай ус усны, 3.9 МПа хүртэл даралттай уур усны дулаан солилцуулагчтай, Хэрэглэгч дулаан хуваарилах төв хоёрын байршлын өндрийн зөрүү нь 51 метрээс их дулаан хуваарилах төв	5.13. 200°C-с их температуртай ус усны, 3.9 МПа-с их даралттай уур усны дулаан солилцуулагчтай дулаан хуваарилах төв
13	Дулааны сүлжээ		2.14. 115°C хүртэл температуртай халуун ус, 0.07 МПа хүртэл даралттай уур дамжуулах шугам	3.22. Ду < 500 мм голчтой 200°C хүртэл температуртай халуун ус, 3.9 МПа хүртэл даралттай уур дамжуулах шугам.	4.24. Ду ≥ 500 мм- буюу түүнээс дээш голчтой 200°C хүртэл температуртай халуун ус, 3.9 МПа хүртэл даралттай уур дамжуулах шугам.	5.14. 200°C-с их температуртай халуун ус, 3.9 МПа-с их даралттай уур дамжуулах шугам



**1.3.** Эдэлбэр газрын барилгажилт, тохижилтын гадна гэрэлтүүлэг, цахилгаан хангамжийн салбар шугам сүлжээ

**2.15.** 0.4 кВ хүртэл хэрэглэгчийн цахилгаан сүлжээ

**2.16.** а. 0.4-15 кВ цахилгаан түгээх сүлжээ

б. 0.4-15 кВ цахилгаан түгээх сүлжээ, дэд станцын барилга байгууламж

**3.23.** а. 35 кВ цахилгаан түгээх сүлжээ

б. 35 кВ цахилгаан түгээх сүлжээ, дэд станцын барилга байгууламж

**4.25.** 110 кВ цахилгаан дамжуулах сүлжээ, дэд станц

**5.15.** 220 кВ ба түүнээс дээш цахилгаан дамжуулах сүлжээ, дэд станц

0	1	2	3	4	5	6
15	Ус хангамж, ариутгах татуургын систем	<p><b>1.4.</b> Барилгын тухай хуулийн 10.1.1 дэх ангиллын барилгын гадна ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ</p>	<p><b>2.17.</b> Барилгын тухай хуулийн 10.1.2 дахь ангиллын барилгын гадна ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ</p>	<p><b>3.24.</b> 100.0 м<sup>3</sup>/хон хүртэл хүчин чадалтай ус хангамжийн эх үүсвэр, дамжуулах болон салбар шугам сүлжээ</p> <p><b>3.25.</b> 100.0 м<sup>3</sup>/хон хүртэл хүчин чадалтай ахуйн бохир усны цэвэрлэх байгууламж болон ариутгах татуургын дамжуулах болон салбар шугам сүлжээ</p> <p><b>3.26.</b> 50 м<sup>3</sup>/хон хүртэл хүчин чадалтай найрлагаараа ахуйн бохир устай төстэй үйлдвэрийн бохир усны цэвэрлэх байгууламж</p>	<p><b>4.26.</b> 101.0 м<sup>3</sup>/хон-с дээш хүчин чадалтай ус хангамжийн эх үүсвэр, дамжуулах шугам сүлжээ,</p> <p><b>4.27.</b> 101.0 м<sup>3</sup>/хон-с дээш хүчин чадалтай ахуйн бохир усны цэвэрлэх байгууламж болон ариутгах татуургын дамжуулах шугам сүлжээ,</p> <p><b>4.28.</b> 51.0 м<sup>3</sup>/хон-с дээш хүчин чадалтай үйлдвэрийн бохир усны цэвэрлэх байгууламж (найрлага нь химийн болон хүнд металлийн бохирдолтой)</p> <p><b>4.29.</b> Нийслэл, бүсийн тулгуур төв хот, бүс нутгийн түвшний ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, барилга байгууламжийн техник эдийн засгийн үндэслэл</p>	<p><b>5.16.</b> Инженер-геологийн онцгой хүндрэлтэй нөхцөлд баригдах ус хангамж ариутгах татуургын шугам сүлжээ, барилга байгууламж,</p> <p><b>5.17.</b> Шинэ дэвшилтэт технологийг турших нарийн технологи болон барилгын хийцтэй ус хангамж, ариутгах татуургын барилга байгууламж</p>
16	Усны барилга байгууламж	<p><b>1.5.</b> Инженерийн бус буюу энгийн хийцтэй усны барилга байгууламж</p>	<p><b>2.18.</b> Услалтын систем ба цөөрмийн барилга байгууламж</p> <p><b>2.19.</b> Инженерийн хийцтэй усан оргилуур</p>	<p><b>3.27.</b> Усны барилга байгууламжууд (Энэ хүснэгтийн 4.30, 5.18 -д зааснаас бусад) III- IV ангийн байнгын үндсэн байгууламжууд /Энэ төрөлд усан цахилгаан станцын барилга байгууламж хамаарахгүй/</p>	<p><b>4.30.</b> Усны барилга байгууламжуудын II ангийн байнгын, үндсэн байгууламжууд (Энэ хүснэгтийн 3.27-д зааснаас бусад)</p>	<p><b>5.18.</b> Усны барилга байгууламжуудын I ангийн байнгын, үндсэн байгууламжууд (Энэ хүснэгтийн 4.30-д зааснаас бусад)</p>

0	1	2	3	4	5	6
17	Мэдээлэл, холбоо - сүлжээний барилга байгууламж		<p><b>2.20.</b> Баригдсан барилга байгууламж болон байгууллагын дотоод хэрэглээний мэдээлэл холбоо, дохиоллын сүлжээ</p>	<p><b>3.28.</b> Орон сууц, олон нийтийн барилга, цогцолбор хорооллын барилга байгууламжийн гадна холбооны шугам сүлжээ</p> <p><b>3.29.</b> Харилцаа холбооны мэдээлэл, технологийн цогцолбор барилга байгууламж болон мэдээлэл холбооны үйлчилгээний төв, мэдээлэл холбооны (агаарын, газрын, сувагчлалын) гол болон салбар шугам сүлжээ, харилцаа холбооны тоон төв (сансрын, эфирийн) болон дэд станц (АТС), үүрэн холбооны бааз (зогсуурын) станцын байгууламж</p> <p><b>3.30.</b> Авто зам, гудамж талбайн дохиолол, хамгаалалт, хяналтын системийн барилга байгууламж, нийтийг хамарсан зарлан мэдээлэх системийн байгууламж</p>	<p><b>4.31.</b> Мэдээллийн сан (дата) төвийн барилга байгууламж</p> <p><b>4.32.</b> Олон улсын хэмжээний төсөл, хөтөлбөрөөр хэрэгжих харилцаа холбооны цогц шийдэл бүхий томоохон хэмжээний цогцолбор барилга байгууламж, мэдээлэл холбооны шугам сүлжээ</p> <p>Тайлбар: Энэ тохиолдолд ТЭЗҮ гаргана.</p>	-

0	1	2	3	4	5	6
18	Газрын тосны барилга байгууламж	1.6. Байгууллагын дотоодын хэрэгцээг хангахад зориулсан зөөврийн ердийн түр агуулах (Энэ хүснэгтийн 5.9-д зааснаас бусад)	-	<p>3.31. Шатахуун түгээх станцын барилга байгууламж, түүний дагалдах үйлчилгээний барилга (худалдаа, хоолны газар, амрах буудал, техник үйлчилгээ, машин угаалгын газар, харуул хамгаалалттай зогсоол г.м)</p> <p>3.32. Газрын тос, газрын тосны бүтээгдэхүүн, хий дамжуулах шугам хоолой, шахуургын станцын барилга байгууламж</p>	<p>4.33. 10000 м<sup>3</sup> хүртэл багтаамжтай газрын тос, газрын тосны бүтээгдэхүүн, шингэрүүлсэн хийн агуулах, шилжүүлэн ачих байгууламж</p> <p>4.34. Газрын тос ба хийн цооногийн байгууламж</p> <p>4.35. Газрын тос, хийн ордны дэргэдэх газрын тос, хий, ус цуглуулах, тээвэрлэх, ордын технологийн дамжуулах шугам хоолой, шахуургын станцын барилга байгууламж</p>	<p>5.19. 10001 м<sup>3</sup>-ээс илүү багтаамжтай газрын тос, газрын тосны бүтээгдэхүүн, шингэрүүлсэн хийн агуулах, шилжүүлэн ачих</p> <p>5.20. Газрын тос, газрын тосны бүтээгдэхүүн, шингэрүүлсэн хий боловсруулах үйлдвэр газар доорх агуулах (Энэ хүснэгтийн 4.33, 5.19-д зааснаас бусад)</p> <p>5.21. Улс дамнасан нефть болон хийн хоолой</p> <p>5.22. Нүүрснээс газрын тосны бүтээгдэхүүн, нийлэг хий боловсруулах үйлдвэрийн барилга байгууламж,</p>
19	Цамхаг, тулгуур, түшиц хана түүнтэй адил байгууламж	-	<p>2.21. 15 м хүртэл өндөртэй цамхаг, тулгуур, түшиц хана болон түүнтэй адил байгууламж</p> <p>2.22. 15 м хүртэл өндөртэй утааны яндан</p>	<p>3.33. 30 м хүртэл өндөртэй цамхаг, тулгуур, түшиц хана болон түүнтэй адил байгууламж</p> <p>3.34. 16-30 м хүртэл өндөртэй утааны яндан</p>	<p>4.36. 31-100 м өндөртэй цамхаг болон түүнтэй адил байгууламж</p> <p>4.37. 31-150 м өндөртэй утааны яндан</p> <p>4.38. Инженерийн байгууламжийн агаарын шугамын 100 м хүртэл өндөртэй тулгуур ба тулгуурын суурь</p>	<p>5.23. 101 м-ээс өндөр цамхаг болон түүнтэй адил байгууламж</p> <p>5.24. 151 м-ээс өндөр утааны яндан</p> <p>5.25. Инженерийн байгууламжийн агаарын шугамын 101 м-ээс дээш өндөртэй тулгуур ба тулгуурын суурь</p>

0	1	2	3	4	5	6
20	Өргөх байгууламж				<p>4.39. Цамхагт, өөрөө явагч, гүүрэн төрлийн кран, манипуляторт кран, сагстай өргөгч, өргүүр 51 метр хүртэлх өндөртэй барилга байгууламжид ашиглах</p> <p>4.40. Лифт 2.5м/с хүртэл хурдтай</p> <p>4.41. Эскалатор 0.5м/с хүртэл хурдтай</p>	<p>5.26. Цамхагт, өөрөө явагч, гүүрэн төрлийн кран, манипуляторт кран, сагстай өргөгч, өргүүр 51 метрээс дээш өндөртэй барилга байгууламжид ашиглах</p> <p>5.27. Лифт 2.5м/с-ээс дээш хурдтай</p> <p>5.28. Зорчигчийн дүүжин зам хурднаас шалтгаалахгүйгээр 5-р ангилалд багтана.</p>

0	1	2	3	4	5	6
21	Хөдөө аж ахуйн зориулалттай барилга байгууламж	-	<p><b>2.23.</b> Үр тариа цэвэрлэх, хатаах байгууламж</p> <p><b>2.24.</b> 1га-гаас илүү талбайтай хүлэмжийн аж ахуй</p> <p><b>2.25.</b> 300 мянга хүртэл толгой шувууны өндөгний аж ахуй, 6 сая хүртэл тахианы махны аж ахуй, 1 мянга хүртэл шувууны аж ахуйн барилга байгууламж</p> <p><b>2.26.</b> Сүү үйлдвэрлэлийн чиглэлийн мал аж ахуйн цогцолборын барилга байгууламж</p> <p><b>2.27.</b> 1000 толгой хүртэл хүчин чадалтай үхрийн аж ахуй, төл бойжуулах, тэжээх барилга байгууламж</p> <p><b>2.28.</b> 500 толгой хүртэл хүчин чадалтай гахайн аж ахуйн барилга байгууламж</p>	<p><b>3.35.</b> Үр тариа хадгалах ба боловсруулах барилга байгууламж (үр тариа цэвэрлэх, хатаах байгууламж хамаарахгүй)</p> <p><b>3.36.</b> 1000 толгойгоос дээш хүчин чадалтай үхрийн аж ахуй, төл бойжуулах, тэжээх барилга байгууламж</p> <p><b>3.37.</b> 500 толгойгоос дээш хүчин чадалтай гахайн аж ахуйн барилга байгууламж</p> <p><b>3.38.</b> 300 мянгаас дээш толгой шувууны өндөгний аж ахуй, 6 саяас дээш тахианы махны аж ахуй, 1 мянгаас дээш шувууны аж ахуйн барилга байгууламж</p>	-	-

0	1	2	3	4	5	6
22	Бусад барилга байгууламжууд	-	-	-	4.41. Газар доорх гарц, инженерийн шугам сүлжээний хонгилын систем	5.29. Цөмийн эрчим хүчний барилга байгууламж 5.30. Метроны барилга байгууламж 5.31. Туннелийн барилга байгууламж
		-	-	-	-	5.32. Төмөр замын I ангиллаас багагүй шугамын барилга байгууламж, түүний доторх төмөр замын туннель, зам, станцын барилга байгууламж, төхөөрөмж
		1.7. Хоногт 5тн хүртэл тэжээл, эрдэс бордоо үйлдвэрлэх үйлдвэр	2.29. Хоногт 5тн-оос дээш тэжээл, эрдэс бордоо үйлдвэрлэх үйлдвэр	-	4.42. Химийн үйлдвэрлэлийн барилга байгууламж /хүний эм үйлдвэрлэх барилга байгууламж/	5.33. Химийн хорт болон аюултай бодис үйлдвэрлэх үйлдвэрийн барилга байгууламж
23	Түр барилга байгууламж	1.8. Түр барилга байгууламж Барилгын ажил зохион байгуулах, гүйцэтгэх, барилга барьж байгаа байгууллагын ажиллагсдад үйлчлэх ашиглаж байгаа (үйлдвэрлэлийн болон туслах) барилга байгууламжууд	-	-	-	
		1.9. Зөөврийн болон туслах барилга байгууламж	-	-	-	-
		2.30. Гадна зар сурталчилгааны байгууламж	-	-	-	-

0	1	2	3	4	5	6
24	Хөргөх байгууламжийн технологийн тоног төхөөрөмжийн угсралт	<p><b>1.10.</b> Амины орон сууцны халаалт агаар сэлгэлт, кондиционерийн шугам сүлжээ угсралт</p>	<p><b>2.31.</b> 10 нр хүртэлх хүчин чадал бүхий төрлийн хөргөх, агааржуулах тоног төхөөрөмж тэдгээрийн угсралтын ажил</p> <p><b>2.32.</b> Агаар сэлгэлт нь ердийн системээр төлөвлөгдсөн барилга</p> <p><b>2.33.</b> 20 тн бүтээгдэхүүн хадгалах эсвэл 100 м<sup>3</sup> хүртэлх эзлэхүүнтэй хөргөлттэй агуулахын тоног төхөөрөмж, тэдгээрийн барилга байгууламжийн угсралт, суурилуулалт</p>	<p><b>3.39.</b> 15-31 метр хүртэл өндөртэй барилгад суурилагдах бүх төрлийн төвлөрсөн хөргөлтийн систем, төхөөрөмжүүд тэдгээрийн угсралт</p> <p><b>3.40.</b> Агаар сэлгэлтийн механик системээр төлөвлөгдсөн барилга</p> <p><b>3.41.</b> Галын болон утааны эсрэг систем төлөвлөгдсөн барилга</p> <p><b>3.42.</b> 20 тн бүтээгдэхүүн хадгалах эсвэл 100 м<sup>3</sup>-ээс дээш эзлэхүүнтэй хөргөлттэй агуулахын тоног төхөөрөмж, тэдгээрийн барилга байгууламжийн угсралт, суурилуулалт</p>	<p><b>4.43.</b> 31-51 метр хүртэл өндөртэй барилгад суурилагдах бүх төрлийн төвлөрсөн хөргөлтийн систем, төхөөрөмжүүд тэдгээрийн угсралт</p> <p><b>4.44.</b> Барилгын нэгдсэн удирдлагын систем болон хөргөлт, агаар сэлгэлтийн иж бүрэн автомат систем төлөвлөгдсөн барилга</p> <p><b>4.45.</b> Шилэн фасадтай барилгын хөргөлтийн болон агаар сэлгэлтийн тоног төхөөрөмжийн угсралт</p> <p><b>4.46.</b> Үйлдвэрлэлийн дэргэдэх бүх төрлийн хөргөлттэй агуулахын угсралт</p> <p><b>4.47.</b> 1000 тн-оос дээш багтаамжтай хөргөлттэй агуулахын тоног төхөөрөмж, тэдгээрийн барилга байгууламжийн угсралт</p> <p><b>4.48.</b> Амархан мууддаг тусгай температур, параметрууд шаарддаг бүх төрлийн хүнсний бүтээгдэхүүн хадгалах хөргөлттэй агуулахын тоног төхөөрөмж, тэдгээрийн байгууламжийн угсралт</p>	<p><b>5.34.</b> 16 давхар буюу 51 метрээс өндөр барилгын бүх төрлийн хөргөлтийн болон агаар сэлгэлтийн тоног төхөөрөмжийн угсралт</p> <p><b>5.35.</b> Эмнэлгийн болон тусгай зориулалтын (холбоо, төвлөрсөн дата сервер, цахилгааны өндөр хүчдэл дамжуулах, түлш болон шатамхай хий, тэсэрч дэлбэрэх аюултай тоноглолтой) барилгын хөргөлт халаалт агааржуулалтын тоног төхөөрөмжийн төлөвлөлт суурилуулалт</p> <p><b>5.36.</b> 3000 тн-оос дээш багтаамжтай хөргөлттэй агуулахын тоног төхөөрөмж, тэдгээрийн барилга байгууламжийн угсралт</p> <p><b>5.37.</b> Бүх төрлийн аммиакийн хөргөлтийн системийн тоног төхөөрөмж, тэдгээрийн барилга байгууламжийн угсралт</p> <p><b>5.38.</b> Бүх төрлийн вакцин болон эм, эмнэлгийн зориулалттай бүтээгдэхүүн хадгалах хөргөлттэй агуулахын угсралт</p>



**Тайлбар: Техникийн шинж чанар:** Барилга байгууламжийн тоон утгаар болон тоон утгаар үл илэрхийлэгдэх шинж чанар (зориулалт, хүчин чадал, овор хэмжээ, урт, хөдөлгөөний хурд, эрсдэл, хариуцлагын болон галын зэрэглэл, хөдөлгөөний болон барилгажилтын нягтрал, техник-эдийн засгийн шинж чанар, онцгой байдлын нөхцөлд үүсэж болзошгүй эдийн засаг-нийгмийн болон экологийн үр дагавар);

-----oOo-----

